

2019 ОНЫ 3 ДУГААР САРЫН 29-НИЙ ӨДРИЙН АЙМГИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ
ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

№	Өгөгдсөн үүрэг даалгаврын товч агуулга	Хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтан	Биелэлт
1	Байгууллагын дарга нар сахилга, хариуцлагаа сайжруулан ажлын цагийг чанд баримтлан ажиллах	7 хоног	Бүх байгууллагын дарга нарт	Тус байгууллагын ажилтан албан хаагч нар ажлын цагийг үр бүтээлтэй, таслахгүй, чанд баримтлаж ажиллаж байна.
2	Өлгий хотын А бүсэд байрлалтай байгууллагуудын урьд талын шороог цэвэрлүүлэх, цаашид уг газруудыг байгууллагуудад хуваарилан өгч зүлэгжүүлэх,цементэн болгох асуудлыг шийдвэрлэх	7 хоног	Өлгий сумын Засаг даргад	
3	Цас мөс хайлж, усны түвшин нэмэгдэж байгаатай холбогдуулан мэргэжлийн байгууллагууд ард иргэдэд шар усны аюулаас урьдчилан сэргийлэх талаар мэдээ, мэдээллийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр хүргэжханхааруулах	7 хоног	Аймгийн ОБГ-ын даргад	
4	Аймгийн хэмжээний хүүхдийн цэцэрлэгүүдийн хамрагдалтад анхаарал тавьж, сайжруулах чиглэлээр ажил зохион байгуулах	7 хоног	Аймгийн БСУГ-ын даргад	
5	Компаниуд барилга байгууламжийг барих үед гарсан хогийг цаг тухайд нь цэвэрлэж байгаа байдалд мэргэжлийн байгууллага хяналт тавьж ажиллах	7 хоног	МХГ	<p>1. Прокурорын ажилтны орон сууцны дэргэд баригдаж буй 4 давхар оффиссын зориулалттай барилгын ажлын үед гарсан барилгын хог хаягдлыг холбогдогч эздээр нь цэвэрлүүлж, Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага тооцов.</p> <p>2. Барилгын ажил барьж буй 6 аж ахуйн нэгж байгууллагуудад хогийг цэвэрлүүлж, хашаа татуулж, анхааруулга тэмдэг тэмдэглэгээ, аюулгүй байдлын хувьцастай болгож ажиллав.</p>

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

2019 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 01-НИЙ ӨДРӨӨС ЭХЛЭН
7 ХОНОГИЙН ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ

№	Хийж хэрэгжүүлсэн ажил	Дараа долоо хоногт хийж хэрэгжүүлэх ажил
1	<p>“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй-2019”, “Эрүүл аюулгүй орчин-таны оролцоо” “Иргэдийн оролцоотой байгаль орчны хяналт” сарын аянуудын хүрээнд аймгийн Засаг дарга ажлын хэсэг байгуулах тухай Захирамж гаргаж, уг захирамжийн хүрээнд Засаг даргын Тамгын газар, Мэргэжлийн хяналтын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Үйлдвэрчний эвлэлийн холбоо хамтран 19 төрлийн ажил хэрэгжүүлэхээр төлөвлөж, Засаг даргын орлогч, Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн дарга А.Камелиятаар батлуулан хэрэгжүүлж ажиллаж байна.</p> <p>Төлөвлөгөөний дагуу 2019 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр хамтарсан арга хэмжээний нээлтийг Агайын ХХК-ийн гүйцэтгэж буй сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилгад хийв.</p> <p>Нээлтэд аймгийн Засаг дарга А.Гылымхан, Мэргэжлийн хяналтын газрын дарга Б.Мухамед, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга К.Бекжан, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга Б.Съезхан, Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга А.Кеншилик нар оролцож, аяны зорилго, ач холбогдол, хийж хэрэгжүүлэх ажлын талаар оролцогчдод танилцуулав.</p> <p>Аяны хүрээнд барилга, хөнгөн үйлдвэрийн салбарын сургалтууд хийгдэж эхлэв.</p>	
2	<p>2019 оны мэргэжлийн хяналтын байгууллагын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу МХГ-ын даргын баталсан 04/150,151 тоот удирдамжуудын хүрээнд Цэнгэл, Сагсай сумын соёлын төвд төлөвлөгөөт хяналт шалгалтыг 6.7 Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтыг шалгах хяналтын хуудсаар хийж гүйцэтгэв.</p> <p>Хяналтын хуудасны үнэлгээгээр Их эрсдэлтэй үнэлэгдсэн ба орон нутаг судлах танхим, сумын номын сангуудын үйл ажиллагаатай танилцаж, илэрсэн дутагдлуудыг арилгуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, Цэнгэл сумын соёлын төвд 9, Сагсай сумын соёлын төвд 11 заалттай нийт 20 заалттай 2 албан шаардлага хүргүүлсэн. Мөн 6.2 Соёлын өвийг хадгалан хамгаалагч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлтээр эрсдэлийн үнэлгээ хийх зөвлөмжийн дагуу 2019 оны эрсдэлийн үнэлгээг хийж, Сагсай сумын соёлын төвийн орчны хогоо цэвэрлүүлэн ажилласан.</p>	
3	<p>Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоол, БСШУС Сайдын А/648 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2018 оны А/827 тоот захирамж, Мэргэжлийн хяналтын Еөрөнхий газрын даргын баталсан 01/12 тоот удирдамжийн хүрээнд аймгийн Музей, Цэнгэл, Сагсай, Улаанхус сумдын орон нутаг судлах танхимд байгаа түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт хамгаалалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж, түүх, соёлын хөдлөх дурсгалын улсын тооллогын салбар комиссын бүрэлдэхүүнтэй хамт улсын тооллогын үйл ажиллагаанд хяналт тавьж илэрсэн зөрчлийг арилгуулах чиглэлээр 6 ажилтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан</p>	
4	<p>“ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖЬЕ-ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭ” ЗӨВЛӨГӨӨН ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 23, 59 дүгээр тогтоол, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын “Хариуцлагатай хэрэглээ-Хэрэглэгчийн эрхийн жил-2019” болгон зарласан шийдвэр, аймгийн Засаг даргын Монгол</p>	

	<p>Улсын Шадар сайдтай байгуулсан гэрээний биелэлтийг хангах ажлын хүрээнд аюулгүй бараа бүтээгдэхүүнээр хангах, соёлтой хэрэглээг бий болгох, зах зээлд бизнес эрхлэгчдийг шударгаар өрсөлдөх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр Өлгий сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн хурлын зааланд “Үндэсний үйлдвэрлэлийг дэмжье-Хариуцлагатай хэрэглээ” нэгдсэн зөвлөгөөн зохион байгуулагдав.</p> <p>Зөвлөгөөнд аймаг, сумдын удирдлагууд болон бизнес эрхлэгчид, сумдын хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус зөвлөлийн гишүүд, ТББ-ын төлөөлөл, иргэд, хэвлэл мэдээллийн төлөөлөл зэрэг нийт 300 орчим хүн хамрагдаж, Засаг даргын Тамгын газар, Гаалийн газар, Мэргэжлийн хяналтын газар, СХЗХэлтэс, Хүнс, хөдөө, аж ахуйн газар, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус салбар зөвлөл, ХЭАХН, Файн ноос ХХК, Дэлхийн зөн Монгол ОУБ–ууд хамтран зохион байгууллаа.</p> <p>Мөн зөвлөгөөнд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга, Мэргэжлийн хяналтын улсын байцаагч Б.Мухамед аймгийн хэмжээнд хүнс, хүнсний бүтээгдэхүүн худалдан борлуулж байгаа аж ахуйн нэгж, иргэдэд гарч буй нийтлэг зөрчил дутагдал, Мэргэжлийн хяналтын газраас тавьж буй шаардлага, хүнсний аюулгүй, баталгаат байдлыг хангуулах, цаашид анхаарах асуудлуудын талаар мэдээлэл хийлээ.</p>	
5	<p>Баян-Өлгий аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 2019 оны 04/112 тоот удирдамжийн дагуу Өлгий-Даян-Улсын чиглэлийн А15 дугаартай авто замын засвар арчлалтын ажилд хариуцагч Жол ХХК-ийн инженер техникийн ажилтан нарыг байлцуулан хяналт шалгалтыг гүйцэтгэж улсын байцаагчийн дүгнэлт гарган Зам, тээврийн хөгжлийн яамны Зам, тээврийн хөгжлийн төв, Жол ХХК-д хүргүүлэв.</p>	7 хоног
6	<p>Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын хэлтсээс Баян-Өлгий аймгийн хууль сахиулах болон Цагааннуур боомт дахь хил, хяналтын байгууллагуудын бүрэлдэхүүнтэй хамтран хил орчмын бүсэн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, хилийн зурваст нутаглаж байгаа ард иргэдэд хил орчмын дэглэмийн биелэлтийг, холбогдох хуулиудыг сурталчлах, мэдээлэл хийх, гарч болзошгүй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх замаар зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, Цагааннуур боомт орчмын 3 цайны газар, 4 дэлгүүрийн үйл ажиллагаанд хяналт хийж, нийт 7 төрлийн гарын авлагаар ханган ажиллав.</p>	
7	<p>Өлгий сумын 5 дугаар багийн иргэний өргөдлийн дагуу Ах дам захаас Ховд голын төмөр бетон гүүр чиглэлийн хотын гол магистрал авто замын уулзвар хүртэлх хотын чанартай авто замын зурвас газрын засвар арчлалт, цэвэрлэгээний ажлыг уг замын барилгын ажлыг гүйцэтгэж байгаа Жол ХХК-иар гүйцэтгүүлэв.</p> <p>Өлгий-Цагааннуур-Улсын хил, Өлгий-Ховд чиглэлийн авто замуудын зурвас газар, хөвөө, хоолойн орох гарах амсар, ус сарниулагч худаг, үерийн далан суваг, шуудуунд хаясан чулуу, хог хаягдал, малын сэг зэм, том жижиг хэмжээний хатуу болон зөөлөн материалын хаягдлыг хариуцагч Жол ХХК цэвэрлэсэн болно.</p>	
8	<p>Газрын даргаас өгсөн үүрэг даалгаврын дагуу барилгын ажил эхлүүлж буй аж ахуйн нэгж байгууллагуудад хяналт шалгалт хийх явцад Өлгий сумын 13 дугаар багийн нутаг дэвсгэрт шинээр баригдах сургууль, цэцэрлэг, спорт заалны цогцолбор барилгын ажлыг гүйцэтгэж буй компани нь ажилчдыг ажлын хувцас, хамгаалах хэрэгсэлгүй ажиллуулж байсан зөрчлийг илрүүлж, арилгуулан ажиллалаа.</p>	

Мэдээллийг нэгтгэсэн:

Х.Жанар